



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 4/33

Улаан-Уул

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний
хүрээнд иргэн бүр мод тарьж ургуулах
хөдөлгөөн зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэр нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1, 31 дүгээр зүйлийн 31.2, Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.4 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63, 2021 оны 58 дугаар зарлигийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖИЛАХ НЬ:

1. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд иргэн бүр мод тарьж ургуулах ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 2022 оны 10 дугаар сарын 15-ны хооронд зохион байгуулсугай

2. Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг сумын хэмжээнд зохион байгуулах ажлыг хэсгийг нэгдүгээр хавсралтаар, ажлын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд иргэн бүр мод тарьж, ургуулахыг удирдамж, төлөвлөгөөний дагуу сумын хэмжээнд зохион байгуулж, мод тарих ажилд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг өргөнөөр татан оролцуулж үр дүнг тооцож, тайлагнахыг ажлыг хэсгийн ахлагч болон гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГА  Т.ЭРДЭНЭБАТ



642201037

Сумын Засаг даргын 2022 оны 23 дүгээр
сарын 10-ний өдрийн А/33 дугаар
захирамжийн хавсралт

ТЭРБУМ МОД ҮНДЭСНИЙ
ХӨДӨЛГӨӨНИЙГ СУМД ЗОХИОН
БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

Ахлагч: Б.Баттулга (Ирээдүй цэцэрлэгийн эрхлэгч)

Гишүүд: Ж.Машбат (Байгаль хамгаалагч)

Д.Батжаргал: (Байгаль хамгаалагч)

Т.Ариунзаяа: (Газрын даамал)

Г.Нямдаваа: Улаан-Уул багийн Засаг дарга

М.Эрдэнэхорол: (Сургуулийн багш)

Д.Төмөр: (Ахмадын төлөөлөл)

Н.Алтантуяа: (Иргэдийн төлөөлөл)

Нарийн бичиг: Байгаль орчны хяналтын улсын байцаагч Т.Мөнхжаргал

-----o0o-----